



**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ**

14251 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 11,
Утас: 6226-3168, Факс: (976-11) 31-23-15,
E-mail: info@mrd.gov.mn, http://www.mrd.gov.mn

2018.07.24 № 08/3507
танай _____-ны № _____-т

**ДАЛАЙН ЗАХИРГААНЫ
ДАРГА С.ТҮВШИНТӨР ТАНАА**

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн “Ажлын хэсэг шинэчлэн батлах тухай” 157 дугаар тушаалын хуулбар хувийг хавсралтаар хүргүүлж байна.

Холбогдох арга хэмжээ авч ажиллана уу.

Хавсралт: 4 хуудастай.

ТӨМӨР ЗАМ, ДАЛАЙН ТЭЭВРИЙН
БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ
ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН ДАРГА

Б.АРТУР



083417



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 159

Улаанбаатар хот

Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хууль тогтоомжийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 10 дугаар зүйлийн 10.1.2, Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын хууль тогтоомжийг боловсронгуй болгох Үндсэн чиглэлийн 73 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг холбогдох судалгаа, тооцоо, мэдээ, мэдээллээр хангах, хуулийн төслийн хэлэлцүүлэг хийх, мэдээлэл сурталчилгааны ажилд шаардагдах зардлыг санхүүжүүлэхийг Далайн захиргаа /С.Түвшинтөр/-нд даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Зам, хөгжлийн тээврийн сайдын 2018 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн "Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай" 27 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД  Ж.БАТ-ЭРДЭНЭ



Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны ...
дугаар сарын ... ны өдрийн ... дугаар
тушаалын нэгдүгээр хэсрэлт

Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл
боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн

УХА0382
5919487
1116126781

Ажлын хэсгийн дарга: Д.Жавхлан

Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг
зохицуулах газрын Далай ашиглалт, усан замын тээврийн
хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга: Б.Нарантунгалаг

Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг
зохицуулах газрын Далай ашиглалт, усан замын тээврийн
хэлтсийн мэргэжилтэн

Гишүүд:

С.Мяндасмаа Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн
хэлтсийн ахлах мэргэжилтэн

Ш.Амаржаргал Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн


Д.Ганбаатар Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг
зохицуулах газрын Далай ашиглалт, усан замын тээврийн
хэлтсийн ахлах мэргэжилтэн

Н.Оюунбилэг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын
ахлах мэргэжилтэн

С.Түвшинтөр Далайн захиргааны дарга

Ч.Оюунцэцэг Далайн захиргааны Хууль, тогтоомж хариуцсан
мэргэжилтэн

Б.Алтан-Од Далайн захиргааны Далбааны эзэн улсын хяналт,
шалгалт хариуцсан мэргэжилтэн



Зам, тээврийн хэрэгсэл сайдын 2018 оны
157 дүгээр сарын 29-ны өдрийн
дугаар шийдвэрээр хавсралт

ДАЛАЙ АШИГЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гүйцэтгэх ажил	Хугацаа /2018 он/	Хууль тогтоомжийн тухай хуулийн зүйл, заалт	Хүрэх үр дүн
1	Далай ашиглах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх	VII - VIII сард	51 дүгээр зүйл 1. хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгах; 2. хууль тогтоомжийн хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа зөрөг, сөрөг байдлыг тодорхойлох; 3. зохистой, үр дүнтэй хэрэгжих, хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлох.	Хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын дагуу хийсэн байна.
2	Хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулах, үзэл баримтлалыг Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх, үзэл баримтлалыг батлуулах арга хэмжээ авах	VIII- IX сард	14, 15 дугаар зүйл 1. хууль тогтоомжийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага 2. хууль тогтоомжийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ 3. хууль тогтоомж батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал 4. хууль тогтоомжийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал	Хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсны үндсэн дээр үзэл баримтлалын төсөл боловсруулагдаж, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Зам, тээврийн хөгжлийн сайд нар хамтран баталсан байна.
3	Хуулийн төслийг үзэл баримтлалд нь нийцүүлэн боловсруулах	VIII- IX сард	16 дугаар зүйл Хуулийн төслийг аргачлалын дагуу боловсруулах: 1. Ерөнхий үндэслэл 2. Хуулийн төсөлд тавих нийтлэг шаардлага 3. Хуулийн үндсэн найруулга, хэллэг, бүтэц	Хуулийн төслийн үзэл баримтлалд нийцүүлэн Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын дагуу хуулийн төслийг боловсруулсан байна.
4	Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоог хийх	IX сард	17, 18 дугаар зүйл 1. харилцан уялдааны шинжилгээ 2. давхардал, хийдэл, зөрчлийг арилгах 3. урьдчилан тооцоогүй үр дагавар 4. зардлын тооцоог аргачлалын дагуу хийх	Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал болон Хууль тогтоомжийг хэрэгжүүлдэг үйл хөдлөлд гаргах зардлын тооцоог хийх аргачлалын дагуу хуулийн төслийн үр нөлөөний

Сайд Төрийн нарийн бичгийн даргын ... оны ... дугаар тушаал

				үнэлгээ, зардлын тооцоо хийгдсэн байна.
5	Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх иргэн, хуулийн этгээдийн төлөөлөл, олон нийтээр хуулийн төслийг хэлэлцүүлж, санал авах, холбогдох саналыг хуулийн төсөлд тусгах эсэхийг шийдвэрлэх	IX сард	38 дугаар зүйл 1. бичгээр санал авах 2. уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах 3. санал асуулга явуулах 4. олон нийтийн цахим сүлжээгээр хэлэлцүүлэг явуулах	Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх иргэн, хуулийн этгээдийн төлөөлөл, олон нийтээр хуулийн төслийг хэлэлцүүлж, саналыг үндэслэлтэй бол хуулийн төсөлд тусгасан байна.
6	Хуулийн төсөлд холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн судалгааны болон судалгааны байгууллагын саналыг авах	IX сард	39 дүгээр зүйл Холбогдох саналыг бичгээр авах	Хуулийн төсөлд холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн болон судалгааны байгууллагын саналыг авч, үндэслэлтэй бол хуулийн төсөлд тусгасан байна.
7	Хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх	X сард	20 дугаар зүйл 1. бусад төрийн захиргааны төв болон холбогдох төрийн байгууллагын саналыг авах 2. Сайдын зөвлөлөөр хэлэлцүүлэх 3. ХЗДХЯ-аар хянуулах	Хуулийн төсөл Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэгдэн дэмжигдсэн байна.
8	Хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх	XI сард	40 дүгээр зүйл 1. хуулийн төслийн бүрдүүлбэрийг хангаж, УИХ-ын Тамгын газарт хүргүүлэх 2. эрх зүйн дүгнэлт 3. өргөн мэдүүлэх тов 4. хуулийн төслийг УИХ-ын даргад өргөн мэдүүлэх	Хуулийн төслийн бүрдүүлбэр бүрэн хангагдаж, УИХ-д өргөн мэдүүлсэн байх.

---000---

